



ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН ХОЁР ДОЛОО ХОНОГ ТУТМЫН МЭДЭЭ №9

Нэг. Монгол оронд бүртгэгдсэн шувууны томуугийн сэжигтэй тохиолдол

2025 оны 08 дугаар сарын 01 нээс 09 дүгээр сарын 01 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдээгүй.

Өвчний сэжигтэй эсвэл үхсэн шувууд таарсан тохиолдолд: **ЗӨСҮТ-н 70282853** дугаарт эсвэл дараах холбоосоор мэдээлэл илгээнэ үү. <https://arcg.is/KXDjy>

Хоёр. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн хүний өвчлөл

2025 оны 08 дугаар сарын 01 нээс 09 дүгээр сарын 01 ний хооронд шувууны томуугийн холбогдолтой өвчлөлийн 1 тохиолдол бүртгэгдсэн.

Тохиолдол 1:

Камбоджи улсын Такое мужид 8 сарын 06 нд 6 настай охин өндөр хоруу чанартай шувууны томуугийн H5N1 хэвшинжээр өвдсөн. Тархвар судлалын холбогдлоор хүүхдийн амьдарч буй дүүргийн ойролцоо 1000 орчим шувууд үхсэн. Мөн тухайн хүүхдийн гэрийн тэжээвэр шувуудаас 30 тахиа нь өвчилсөн ба 1 тахиаг нь хүнсэнд хэрэглэсэн.

Гурав. Дэлхий дахинд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн амьтдын мэдээлэл:

2025 оны 08 дугаар сарын 01 нээс 09 дүгээр сарын 01 ний хооронд шувууны томуугийн А хүрээний вирус АНУ, Аргентин, Бельги, Болгар, Камбоджи, Канад, Вьетнам, Энэтхэг, Испани, Португал, Унгар, Ирланд, Норвеги, Өмнөд Африк, Франц, Их Британи зэрэг 16 улс орны газар нутагт нүүдлийн болон тэжээвэр шувуудын дунд 86 тохиолдол бүртгэгдсэн (Дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгт 1, зураг 2 оос харна уу). Ихэвчлэн Өмнөд Америк, Өмнөд Африкийн улс оронд шувууны аж ахуйд, Европ тивийн улс оронд нүүдлийн шувууд, хөхтөн амьтдад, Зүүн Азийн улс оронд өрхийн тэжээвэр шувуудын дунд өвчлөл бүртгэгдсэн.

Шувууны томуугийн халдварыг хиймэл оюун ухааны тусламжтай илрүүлэх судалгааны ажил АНУ-н Мэрилэнд их сургуулийн судлаач нар хийсэн. Эхлээд судлаач нар large language models (LLMs) буюу Их хэл загварчлалыг GTP-4 дээр хөгжүүлсэн. Энэхүү загварчлал нь цуглуулсан асуумж, судалгаа мэдээллийг нэгтгэн дүгнэх, орчуулах, өгүүлбэрийг гүйцээх зэрэг үүргийг гүйцэтгэдэг. Энэхүү загварчлалаар эмнэлэгт үзүүлсэн хүний эрүүл мэндийн хуудас, шинжилгээний хуудсуудыг уншуулсан. Улирлын чанартай томуугаар 2024 онд оношлогдсон 13494 хүний хариуг эргэж шалгасан ба 76 нь шувууны томуугийн халдвар байх эрсдэл өндөр гэж гаргасан. Тэдгээр 76 хүнд баталгаажуулах нэмэлт асуумж судалгаа авахад 14 тохиолдол нь шувууны аж ахуй, томуугийн өвчлөл

бүртгэгдэж байсан үхрийн фермтэй ойр ажиллаж, амьдардаг хүмүүс байсан. Загварчлал хөгжүүлсний дараа энэхүү судалгааг хийхэд 25 минут зарцуулсан ба зардал мөнгө гараагүй байна. <https://doi.org/10.1093/cid/ciaf369>

Хүснэгт 1. Шувууны томуугийн А хүрээний вирусийн хэв шинжээр тархалт

Эх сурвалж: <https://empres-i.apps.fao.org/>

Дэд хэвшинж	Улс	Зүйлийн нэр	Нийт тохиолдол
H5N1	АНУ	Шувууны аж ахуй, муур, тас	4
H5N1	Аргентин	Шувууны аж ахуй	3
H5	Бельги	Мөнгөлөг цахлай, тураг гогой, хун	4
H5N1	Болгар	Шувууны аж ахуй	3
H5N1	Камбоджи	Тахианы аж ахуй, хүний өвчлөл	4
H5N1	Канад	Махчин шувууд	1
H5	Франц	Мөнгөлөг цахлай	4
H5N1	Унгар	Бор галуу	1
H5	Энэтхэг	Шувууны аж ахуй	2
H5N5	Ирланд	Цагаан сүүлт бүргэд	1
H5N1	Норвеги	Мөнгөлөг цахлай	11
H5N1	Португал	Цахлай, нугас	5
H5N1	Өмнөд Африк	Шувууны аж ахуй	2
H5N1	Испани	Хөх дэглий, бор галуу, өрөвтас, зэрлэг нугас, бор нугас	11
H5N1	Их Британи	Шувууны аж ахуй, галуу, цахлай, хараалай, элээ, хун, сар шувуу	26
H5N1	Вьетнам	Шувууны аж ахуй	1

Зураг 1. 2025 оны 08 дугаар сарын 01 нээс 09 дүгээр сарын 01 ний хооронд шувуудын дунд бүртгэгдсэн шувууны томуугийн А хүрээний вирусийн тохиолдлын тархалт

